



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
**ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар
авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Жендэрийн үндэсний хорооны 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн ээлжит хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд салбар, орон нутгийн жендэрийн бодлого, дэд хөтөлбөрөөр дамжуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг хорооны гишүүд, холбогдох байгууллагад үүрэг болгосугай:

1.1. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргачлал боловсруулж батлах, хэрэглээнд нэвтрүүлэхийг Сангийн яаманд;

1.2. Тоо бүртгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналтын холбогдох маягт, журмыг хянан үзэж, хүйсээр ялгасан тоон мэдээ, чанарын шалгуур үзүүлэлтийг тусгахыг бүх шатны төрийн захиргааны байгууллагад;

1.3. Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж насжилтын зөрүүг бууруулах чиглэлээр салбар дундын үйл ажиллагааг нэгдсэн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхийг хорооны гишүүдэд;

1.4. Ажил-амьдралын тэнцвэрийг хангах бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх арга хэлбэрийг судлах, турших, загварчлан түгээхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Хараат бус судалгааны хүрээлэн болон хорооны ажлын албанд;

1.5. Ажлын байран дахь хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах ажлыг зохион байгуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд;

1.6. Төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа сайн туршлага, үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчлах, жендэрийн асуудлаар төр-иргэний нийгэм-хувийн хэвшил-олон улсын түншлэгчдийн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтын ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулахыг хорооны гишүүдэд.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг хорооны нарийн бичгийн дарга /Т.Энхбаяр/-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд,

Жендэрийн үндэсний хорооны дарга

УХУРЭЛСҮХ

